



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ
2018.05.28-05.31

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт Nasdaq индекс хамгийн өндөр өсөлттэй хаагдлаа. Dow Jones индекст багтдаг мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол банк, санхүүгийн салбарын компаниудын хувьцааны ханш урт хугацааны Засгийн газрын бондын өгөөж буурсантай холбогдуулан унажээ.

Европын холбооны улс төрийн тодорхойгүй байдал, АНУ-ын ган, хөнгөн цагааны импортод ногдуулсан тариф болон газрын тосны үнэтэй холбоотой үйл явдлууд энэ долоо хоногт хөрөнгийн зах зээлд нөлөөлсөн байна.

Өнгөрсөн долоо хоногт ОПЕК-ийн улс орнууд газрын тосныхоо гарцыг нэмэх болсонтой холбогдуулан газрын тосны үнэ буурсан ба энэ долоо хоногт тус орнуудын хооронд маргаан үүссэн явдал нөхцөл байдлыг улам хүндрүүлэв.

АНУ-ын 5-р сарын ажил эрхлэлтийн тайлангийн эерэг үзүүлэлтүүд хөрөнгийн зах зээлд эерэг нөлөө үзүүлжээ. Өнгөрсөн сард 223 мянган ажлын байр шинээр бий болж ажилгүйдлийн түвшин 0.1%-аар буурч 3.8% болсон байна.

АНУ дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт энэ оны 1-р улиралд 2.2%-тай тэнцэж, урьдчилан тооцоолсон түвшнээс 0.1% бага байв.

Европ: Итали болон Испани улсуудын улс төрийн байдал Европын компаниудын хувьцааны ханшид нөлөө үзүүлжээ.

Италийн "Таван од" хөдөлгөөн, Умард Лиг нам хамтран Эвслийн Засгийн газар байгуулан, баруун Европын анхны популист Засгийн газрыг байгуулахаар Ерөнхий сайдад Евро бүсийн эсрэг үзэлтэй профессор Пауло Савонаг нэр дэвшүүлсэн юм. Үүнд Италийн Ерөнхийлөгч хориг тавьснаар Эвслийн Засгийн газар байгуулах оролдлого бүтэлгүйтлээ. Энэхүү оролдлого нь Итали улсыг Европын Холбооноос гарахаар зэхэж байна гэсэн эргэлзээ төрүүлсэн байна.

Испани улсын социалист нам бусад найман намын дэмжлэгтэйгээр Ерөнхий сайд ноён Мариано Рахойг халсаны дараа шинэ Засгийн газар байгуулсан. Тус улсын хуучин Ерөнхий сайд олон сая еврогийн авилга авсан хэрэгт буруутгагдсан байна.

Европын холбооны хэрэглээний барааны үнийн индекс 0.7%-аас өсөн 1.1% болжээ. Европын бүсийн Худалдан авах менежерүүдийн индекс 55.5-тай тэнцэж урьдчилан тооцоолсонтой ижил байв.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш уналттай хаагдлаа. Иений ханш ам.долларын эсрэг 109.6 нэгж болон хаагдсан нь 2017 оны эцсээс 3.1%-аар чангарсан байна. Европын орнуудын улс төрийн тодорхойгүй байдлаас үүдэн иений ханш бага зэрэг чангарсан байна.

Японы төв банкны тэргүүн ноён Харухико Курода Засгийн газраас инфляцийн зорилтот түвшинд хүрэх хугацааг хязгаарласан хэмээн мэдэгджээ. Инфляцийн зорилтот түвшинг өөрчлөөгүй учир Японы төв банк мөнгөний бодлогоо зөөллөхгүй хэмээн тус улсын Ерөнхий сайд мэдээлэв.

БНХАУ: "MSCI"-ийн олон улсын хөрөнгийн зах зээлийн жишиг индекст БНХАУ-ын 234 компаниудыг бүртгэсэн нь тус улсын голлох компаниудын хувьцааны ханш унахад нөлөөлжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,024.71	0.44% ▲
Dow Jones	АНУ	24,635.21	-0.48% ▼
S&P 500	АНУ	2,734.62	0.49% ▲
Nasdaq	АНУ	7,554.33	1.62% ▲
S&P/TSX	Канад	16,043.54	-0.20% ▼
FTSE 100	Их Британи	7,701.77	-0.37% ▼
S&P/ASX 200	Австрали	5,990.40	-0.70% ▼
Nikkei 225	Япон	22,171.35	-1.24% ▼
Hang Seng	Хонг Конг	30,492.91	-0.31% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	109.99
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	96.76
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.32
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.78
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.14
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.46
TDBM' 2020	USD	9.3%	106.41

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Үө
Libor 1M	2.005	0.03 ▲
Libor 3M	2.318	0.00 ▼
Libor 6M	2.474	-0.01 ▼
Libor 1YR	2.724	-0.01 ▼
US 6M Bond	2.084	0.02 ▲
US 2YR Bond	2.488	0.01 ▲
US 3YR Bond	2.622	0.01 ▲
US 5YR Bond	2.764	0.00 ▼
US 10YR Bond	2.915	-0.02 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.05.31	Өөрчлөлт
USD	2,409.80	-0.04% ▼
CNY	376.40	-0.22% ▼
EUR	2,821.51	0.13% ▲
RUB	38.85	-0.61% ▼
KRW	2.24	0.45% ▲
JPY	22.16	0.54% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,293.40	-0.68% ▼
Мөнгө /spot/	16.41	-0.61% ▼
Зэс	309.15	0.45% ▲
Нүүрс	107.25	3.97% ▲
WTI газрын тос	65.71	-3.20% ▼
Brent газрын тос	76.79	0.46% ▲
Байгалийн хий	2.98	1.36% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.IV	6.00%
Бодлогын хүү	2018.IV	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.IV	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.IV	12.80%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.IV	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.IV	19.30%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.IV	10.20%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 40 компанийн 2,104.2 сая төгрөгийн 9,302,662 ширхэг хувьцаа арилжигдав.

“Алтайн зам” /AZH/ компанийн хувьцаа 74.71%-аар буюу хамгийн ихээр өсч 2,439 төгрөгт хүрч хаагдсан бол “Баян Алдар” /VIK/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 634.95 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 1,096 ширхэг үнэт цаас 111.4 сая төгрөгөөр арилжаалагджээ.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр мөн л арилжаа явагдаагүй байна.

5-р сарын 31-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,487.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,024.71 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.44%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,260.4
Зах зээлийн үнэлгээ	2,487,830.9

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,024.71	0.44% ▲
MSE I индекс	9,677.27	0.25% ▲
MSE II индекс	10,064.56	0.27% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Монгол Базальт	3,777,486	1,571,389,909
ЛендМН ББСБ	5,288,936	274,960,296
Гутал	3,532	77,703,900
Жуулчин Дюти Фрий	441	41,670,320
АПУ	62,987	39,590,941

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	2,439.00	74.71% ▲
Хөвсгөл алтан дуулга	123.05	32.24% ▲
Хүннү менежмент	164.05	14.99% ▲
Махимпекс	3,000.00	14.90% ▲
Жуулчин дюти фрий	100,000.00	11.11% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Баян Алдар	634.95	-15.00% ▼
Силк нет	615.90	-14.99% ▼
Хөх ган	85.00	-13.27% ▼
Стандарт ноос	500.00	-13.04% ▼
Айтүүлс	136.00	-11.12% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Гаүли	1,131,412,578
БиДиСек	606,206,227
Бумбат Алтай	605,050,386
Мирэ Эссет Секьюритис Монгол	391,705,587
Новел Инвестмент	247,711,002

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	628.00	668,306
Таван толгой	10,020.00	527,705
МИК	10,510.00	217,448
Говь	22,900.00	178,646
Сүү	224.39	77,190

ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-11/04/19-A0230-18	1,000	101,080,000	101,080	101,080	104	18.000%
2	ZGEB-BD-14/02/2019-A0208-18	96	9,600,000	100,000	100,000	104	18.000%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт ХК	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан ХК	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой ХК	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.04.27-с	Тодорхойгүй
4	EER	Ариг гал ХК	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол ХК	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	Тодорхойгүй	Тодорхойгүй
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал ХК	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	AND	Анд-Энерги ХК	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	SUL	Жуулчин дюти фрий ХК	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байран дээр, дансаар
10	GTL	Гутал ХК	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
11	BNG	Баянгол зочид буудал ХК	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байран дээр
12	APU	АПУ ХК	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
13	BTG	Баянтээг ХК	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
14	MIE	Материалимпекс ХК	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
15	HRD	Хүрд ХК	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
16	SUU	Сүү ХК	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.05.21-с	ҮЦТХТ-ийн данс
17	MNP	Монгол шуудан ХК	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
18	MMX	Махимпекс ХК	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байран дээр
19	TCK	Талх чихэр ХК	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байран дээр
20	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
21	ADL	Адуун чулуун ХК	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	Тодорхойгүй	ҮЦТХТ-ийн данс
22	ТАН	Тахь-ко ХК	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
23	UBH	Улаанбаатар хивс ХК	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
24	GOV	Говь ХК	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байран дээр, дансаар
25	HRM	Гермес центр ХК	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн үнэт цаасны арилжааг нээлээ

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааг хувааж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагаа “ҮЦТХТ” ТӨХХК-д хийгдсэн тул СЗХ-ны Улсын байцаагчийн 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 35 тоот албан шаардлагын дагуу “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс нээхээр боллоо.

Эх сурвалж: MSE.mn

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” зах зээлийн мэргэжлийн оролцогчдод үнэт цаасны танилцуулга хийлээ

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн, анхны давхар бүртгэлтэй компани болох Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн (TSX:ERD) нь 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч нарт зориулан үнэт цаасны танилцуулга хийлээ. Тус компани нь нийт хувьцааныхаа 2.7 хувь буюу 4,000,000 ширхэг хувьцааг тус бүрийг нь 640 төгрөгөөр МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгож, нийт 2.56 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх бөгөөд төвлөрүүлсэн хөрөнгийг хайгуулын өрөмдлөг, нөөцийн тооцоолол, техникийн судалгаа хийж гүйцэтгэхэд зарцуулахаар төлөвлөж байна.

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн”-ийн үндсэн андеррайтераар “Би Ди Сек ҮЦК” ХК, туслах андеррайтераар “Голомт капитал ҮЦК” ХХК ажиллаж байгаа бөгөөд 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Туушин зочид буудлын Соёмбо танхимд олон нийтэд зориулсан танилцуулга арга хэмжээг зохион байгуулахаар болсон байна.

Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн худалдан авах захиалгыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 15 цаг хүртэл хүлээн авна.

Эх сурвалж: MSE.mn



“Steppe Gold”-ийн нэгж хувьцааны ханш 5.1 хувиар унав

Торонтогийн Хөрөнгийн биржид өнгөрсөн долоо хоногт хувьцааны анхдагч зах зээлийн арилжаагаа эхэлсэн “Steppe Gold” компанийн нэгж хувьцааны ханш 1.75 канад доллар болсон байна. Өнгөрсөн дөрвөн өдрийн дотор тус компанийн хувьцааны ханш 5.1 орчим хувиар буурчээ.

“Steppe Gold” компанийн IPO-ийн захиалга тавдугаар сарын 22-нд хаагдсан юм. Тус компани Хөрөнгийн зах зээлээс нийт 10.5 сая ширхэг хувьцааг нэгж бүрийг нь хоёр канад доллараар үнэлж, 21.1 сая канад долларын хөрөнгө татсан байна. Мөн нэг нэгж хувьцаа бүр нь энгийн нэг хувьцаанаас гадна “warrant” худалдан авах эрхтэй байсан юм. 2018 он гарснаас хойш Торонтогийн Хөрөнгийн бирж дээр арилжаалсан анхны уул уурхайн салбарын хувьцаа тус компанийн хувьцаа боллоо.

Эх сурвалж: BloombergTv.mn

Сүүлийн 10 жилийн хугацаанд анх удаа 6 сарын дотор 4 компани IPO гаргалаа

Сүүлийн хагас жилийн хугацаанд дотоодод дөрвөн компани IPO хийгээд байна. Өөрөөр хэлбэл 2008 оноос хойш анх удаа хагас жилийн хугацаанд ийм тооны IPO-ийг хөрөнгийн зах зээлд амжилттай гаргаад байгаа юм.

Хөрөнгийн зах зээл идэвхжиж, дараалан гарсан дөрвөн IPO амжилттай болж байгаатай зэрэгцээд шинээр энэхүү зах зээлд орох компаниуд нэмэгдэх хандлагатай байгааг “Би Ди Сек”, “Бумбат Алтай”, “Мирэ Ассет Секьюритис” зэрэг үнэт цаасны компаниуд мэдээлж байна. Мөн 2017 онд анхны хувийн бирж нээгдсэнтэй холбоотойгоор зах зээлд өрсөлдөөн бий болно гэж үзэж байгаа юм.

Үүнээс гадна Монголын Хөрөнгийн биржийн II, III ангилалд бүртгэлтэй идэвх муутай компаниуд хөдөлгөөнд орох хандлагатай байгааг онцолсон юм. Тухайлбал, II ангиллын “Ган хийц” компанитай “Бумбат Алтай” үнэт цаасны компани хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан байна. Ингэснээр цаашид дээрх үнэт цаасны компани нь “Ган хийц” компанийн хэрэгжүүлэх төсөлд зөвлөж, нэмж хувьцаа гаргахад андеррайтераар нь ажиллах ажээ.

Хэдий тийм боловч “Зах зээлд шинээр орж байгаа бүтээгдэхүүнүүдийг дотоодын хөрөнгө оруулагчид түлхүү санхүүжүүлж байгаа”-г “Би Ди Сек” компанийн Гүйцэтгэх захирал онцолсон юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МХБ: “Монгол базальт” ХК-ийн 1.6 тэрбум төгрөгийн хувьцааг арилжив

Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд орж байгаа “Монгол базальт” компанийн хоёрдогч зах зээлийн арилжаа эхэллээ. Тус компани нийт 16.9 сая ширхэг хувьцааг нэг бүрийг нь 380 төгрөгөөр санал болгосон юм. Хэдий тийм боловч бизнес үнэлгээгээр нэгж хувьцаа нь 639 төгрөг байгааг “Монгол базальт” компанийн үүсгэн байгуулагч онцолж байв. Ингэснээр хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаагаа бодит үнэ цэнээс 40.5 хувиар хямд санал болгожээ. Тус компанийн анхдагч зах зээлийн захиалга өнгөрсөн долоо хоногийн лхагва гарагт дууссан юм. Захиалгын хэмжээ олон нийтэд санал болгосон дүнгээс 3.2 дахин давж, 20.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. “Монгол базальт” компани дотоодын дулаалгын материалын зах зээлийн 2.5 хувийг эзэлж байгаа аж. Харин суурилагдсан хүчин чадлаар нь тооцвол тус компани нийт дулаалгын материалын зах зээлийн 20-25 хувийг дангаараа хангах боломжтой гэж мэдээлж байлаа.

Арилжааны эхний өдөр хувьцааны ханш нь 7.98 хувиар өсөж, 410.32 төгрөгт хүрээд байсан. Мөн нийт 1.2 сая ширхэг хувьцаа буюу олон нийтэд байгаа хувьцааны 7.4 хувь нь эргэлтэд оржээ. Арилжааны дүн 509 сая төгрөгт хүрснээр Монголын Хөрөнгийн биржид даваа гарагт идэвхээрээ тэргүүлсэн юм.

Энэ долоо хоногт хоёрдогч зах зээл дээр “Монгол базальт” компанийн нийт 3,777,486 ширхэг хувьцаа арилжигдсан. Харин пүрэв гарагт тус компанийн хувьцааны ханш 413.12 төгрөгт хүрч хаагджээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Bazaltwool” шилдэг ногоон технологиор тодорлоо

Жил бүр уламжлал болсон “Ногоон технологи, эрчим хүчний хэмнэлт-2018” үзэсгэлэн МҮХАҮТ-ын Их танхимд хоёр дахь өдрөө үргэлжилж шилдэг бүтээгдэхүүнээ шалгаруулав.

Энэ удаагийн шалгаруулалт 3 номинациар болсоноос “Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК “Шилдэг эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн”-тэй байгууллагаар шалгарсан бол “Монгол базальт” компани өөрийн үйлдвэрлэдэг байгалийн гаралтай чулуун шилэн хөвөн дулаалгын материалаар “Шилдэг ногоон технологи нэвтрүүлэгч байгууллага”-аар тодорлоо. Харин “ХАС” банк “Шилдэг ногоон санхүүжүүлэгч”-ээр шалгарсан. “Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн хувьд цахилгаан нийлүүлж буй газруудын 70 хувь нь эрчим хүчний ухаалаг тоолуурын системд шилжснээр харилцагч байгууллагууд цахилгаан зарцуулалтаа хянаж хэмнэх боломжтой болсон юм. “Монгол базальт” компанийн хувьд “rockwool” буюу чулуун хөвөн бүтээгдэхүүний үйлдвэрийн үйл ажиллагааг Дани, ОХУ, БНХАУ болон Европын улс орнуудын туршлагаас судалсны үндсэн дээр эх орондоо байгалийн гаралтай, чулуун хөвөн бүхий эко бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийг 2005 оноос боловсруулж нэвтрүүлээд байгаа юм.

Эх сурвалж: Montsame.mn

Арнауд Суарат: Дэлхий нийтээрээ “Оюу Толгой” хэрхэн хөгжиж байгааг ажиглаж байна

“Монгол Улс татвар, роялти төлбөр гэх мэт асуудлаар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд байгалийн баялгаа ашиглан хөгжих бүхий л нөөц бололцоо байна” гэж “Rio Tinto” группийн Зэс, очир эрдэнийн группийн захирал Арнауд Суарат “Монголын эдийн засгийн чуулган 2018”-д оролцох үедээ мэдэгдлээ. Тэрбээр мөн “Дэлхий даяараа “Оюу Толгой”-ийн бүтээн байгуулалтыг ажиглаж байгаа” гэдгийг онцолсон байна. “Оюу Толгойн төсөл нь хөрөнгө оруулалтын гол гэрээнүүдийн халдашгүй байдал дээр тогтдог. Эдгээр гэрээ нь Монгол Улсад 12 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх шийдвэрийн үндэс суурь нь болсон” гэдгийг Арнауд Суарат мөн дурджээ. Одоогоор “Оюу Толгой”-ийн дэд бүтэц, эрчим хүч, татвар, зээлийн асуудлаар шалгалт хийхээр Засгийн газар дөрвөн ажлын хэсэг байгуулаад байна. Мөн “Оюу Толгой”-ийн хөрөнгө оруулалтын гэрээ, гүний уурхайн бүтээн байгуулалтын гэрээний хэрэгжилтийг шалгах УИХ-ын ажлын хэсэг ажиллаж байгаа юм. Мөн “Татварын ерөнхий газар “Оюу Толгой” ХХК-д 155 сая ам.долларын татварын акт тавьсан. Үүний ихэнх дээр талууд санал нэгдэхгүй байгаа учир “Оюу Толгой” ХХК Монгол Улсын Засгийн газарт маргаан шийдвэрлүүлэх хүсэлт өгсөн” талаар “Turquoise Hill Resources” мэдээлээд байна.

“Оюу Толгой” төслийн хүрээнд 2010 оноос хойш 2018 оны I улирал хүртэлх хугацаанд дотоодод 7.5 тэрбум ам.долларын мөнгөн хөрөнгө зарцуулсан талаар мөн мэдээлжээ. Үүнээс 74 хувийг Монгол компаниудад хийсэн төлбөр, 20 хувийг нь улсын төсөвт төлсөн төлбөр, үлдсэн зургаан хувийг ажилчдын цалинд зарцуулжээ.

Үүнээс гадна 2018 оны I улирлын байдлаар төслийн хэмжээнд нийт 14 мянган хүн ажиллаж байгаагийн 94 хувь нь монголчууд, үүнээс 20.6 хувь нь Өмнөговь аймгийн иргэд байгаа ажээ. Мөн татвар хураамж хэлбэрээр 1.5 тэрбум ам.доллар төлсөн талаар “Оюу Толгой” ХХК мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

БНХАУ АНУ-аас авах нүүрсний импортоо нэмэгдүүлнэ

АНУ-тай хийх худалдааны алдагдлыг бууруулах зорилгоор БНХАУ-ын Засгийн газар АНУ-аас авах нүүрсний импортоо нэмэгдүүлэх шийдвэр гаргаж магадгүй байгаа талаар гэж ойрын эх сурвалж мэдээллээ. Ялангуяа баруун Виржинигээс их хэмжээний нүүрс авах хэлцэл хийхээр төлөвлөж байгаа юм байна. АНУ, БНХАУ-ын хооронд үүсээд байгаа худалдааны маргааныг намжаах зорилгоор БНХАУ-ын Засгийн газраас АНУ-ын худалдааны алдагдлыг 200 хүртэл тэрбум ам.доллараар бууруулах саналыг хүргүүлээд байгаа юм. Энэ хүрээнд БНХАУ-ын Засгийн газар автомашинд ногдуулах татварын хэмжээгээ 10 хувиар бууруулсан гэж олон улсын шинжээчид дүгнэжээ. 2017 онд БНХАУ 395 сая ам.долларын нүүрсийг АНУ-аас импортолсон байна. Харин одоогоор энэ тоо хэр хэмжээгээр нэмэгдэх нь хараахан тодорхой болоогүй байгаа ажээ. БНХАУ-ын АНУ-аас авдаг нүүрсний дундаж үнэ тонн тутам 122 ам.доллар байдаг байна. Нөгөө талаар АНУ-ын нүүрсний экспорт эрчимтэйгээр нэмэгдэж байгааг шинжээчид онцолж байгаа юм. Өнгөрсөн онд гэхэд АНУ-ын нүүрсний экспорт 61 хувиар өссөн байна. Ялангуяа Азид нийлүүлсэн нүүрсний хэмжээ хоёр дахин өсөж, 32.8 сая тоннд хүрчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



БНХАУ байгалийн хийн нийлүүлэлтийг өсгөх бодлого баримталж эхэллээ

БНХАУ-ын Засгийн газар байгальд ээлтэй эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор байгалийн хийн нийлүүлэлтийг өсгөх бодлого баримталж эхэллээ. Хэдий тийм боловч алдагдалтай ажиллаж ирсэн компаниудын ашгийг нэмэгдүүлэхийн тулд байгалийн хийн үнийг куб метр тутам 0.35 юаниар нэмэгдүүлэхээр болжээ. Хэдийгээр үнэ нэмэгдэх нь богино хугацаандаа байгалийн хий нийлүүлэгчдийг алдагдалд оруулах эрсдэлтэй боловч урт хугацаандаа салбарын ашгийг нэмэгдүүлж, илүү олон бизнес эрхлэгчдийг энэ салбарт татах болно гэж эрх баригчид үзэж байна. Улмаар 2030 он гэхэд нийт эрчим хүчний 15 хувийг байгалийн хийгээр хангах БНХАУ-ын Засгийн газрын зорилт биелэх боломжтой гэж тооцоолжээ. БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жиньпиний байгальд ээлтэй эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх бодлогууд үр дүнгээ өгсөөр байна. Тухайлбал, өнгөрсөн онд БНХАУ-ын байгалийн хийн эрэлт 15 хувиар нэмэгджээ. Энэхүү өсөлт оны эхний улиралд 17 болтлоо өсөөд байгаа юм. Дэлхий даяар эрдсийн хайгуулд ихээхэн хөрөнгө зарж эхэлж байна. 2012 оноос тасралтгүй буурсан хайгуулын зардлын уналтыг 2017 онд хазаарлан тогтоож чадсан төдийгүй сүүлийн улиралд эрчимтэй өсөлт үзүүлжээ. Хайгуулын өсөлтийг 2018 онд тогтвортой хадгалагдаад зогсохгүй илүү өсөх төлөвийг судалгааны байгууллагууд дэвшүүлж байна. Нэг ёсондоо дэлхий даяар хайгуулын ажил эрчимжиж байна. Уул уурхайн том жижиг компаниуд эрдсийн хайгуулд ихээхэн хэмжээний хөрөнгө зарж эхэлжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Эдийн засаг 6.1 хувиар өсөв

Үндэсний Статистикийн хорооноос гаргасан 2018 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр Монголын эдийн засагт 3.2 их наяд төгрөгт эргэлдэж, өмнөх оны мөн үеэс даруй 188 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Ингэснээр Монголын эдийн засаг 6.1 хувийн өсөлтийг үзүүлж байна. Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 2018 онд 3.1 хувиар өсөх таамаглал дэвшүүлээд байгаа. Харин дотоодын шинжээчдийн дүгнэлтээр эдийн засаг энэ онд илүү эрчимжиж, олон улсын таамаглалыг давах хандлагатай байна. Нийт эдийн засагт үлэмж нөлөөтэй уул уурхайн түүхий эд болох зэс, алт, нүүрсний үнэ харьцангуй өсөлттэй байгаа юм. Улмаар Хятад, Монголын хил дээр үүсээд байгаа нүүрс тээвэрлэлтэд үүссэн урт дарааллыг шийдэж, нэвтрэх гарцыг нэмэгдүүлснээр өдөрт 1000-1400 автомашин хилээр гарах боломж бүрдсэн. Энэ нь гуравдугаар улиралд нүүрсний экспортыг эрчимжихэд нөлөөлжээ.

Нөгөөтэйгүүр гадаад хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх, том төслүүд хөдлөх хүлээлт үүссэн нь эдийн засагт нааштайгаар нөлөөлж байна. Манай улсын эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүний үнийн савлагаанаас болж өгсөж, урууддаг нь нууц биш. Өөрөөр хэлбэл мөчлөг дагаж хувьсаж ирсэн. Тэгвэл 2018 оны хувьд нүүрс, зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр өсч, монголын эдийн засаг тэр дундаа уул уурхайн салбарын өсөлтөд нэлээн жин дарж байгааг мэргэжилтнүүд тодотгож байгаа юм. Тодруулбал экспортын 78.8 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж буй бөгөөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.4 тэрбум ам. доллар, үүнээс нүүрсний экспорт 1.3 тэрбум ам.доллараар тэлэв. Дэлхийн зах зээл дээр нүүрс, зэсийн үнэ энэ хэвээр цааш үргэлжилбэл манай улсын хувьд таатай нөлөө үзүүлнэ гэдэгт эдийн засагчид санал нэгтэй байна. Улмаар эдийн засаг харьцангуй эерэг болсон суурь шалтгааны нэг нь БНХАУ манай улсаас түлхүү нүүрс худалдаж авсан явдал хэмээн шинжээчид тайлбарлаж байна.

Эх сурвалж: Montsame.mn

ЗГ: Өрийг үе шаттай бууруулах бодлого баримтална

Сангийн яамнаас тооцоолсон 2018 оны урьдчилсан үзүүлэлтээр Засгийн газрын өр, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 63.4 хувьтай байна. Энэ нь өндөр эрсдэлтэй байгааг эдийн засагчид онцолж байгаа юм. Өөрөөр хэлбэл орлого багатай улс орны Засгийн газрын өр, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 50 хувиас дээш гарвал дефолт болох эрсдэлтэй, өрийн эмзэг байдал өндөр гэж үздэг ажээ.

Төсвийн хүрээний мэдэгдэлд энэ онд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг найман хувьтай байхаар төсөөлжээ. Хэрэв энэ өсөлтөд хүрэхгүй бол өр, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 63 хувиас дээш давах болж байна. Засгийн газрын өрийг үе шаттайгаар бууруулах бодлого баримтална гэж Сангийн яам мэдээлээд байгаа юм. Тухайлбал, 2019 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 55.3 хувьд, 2020 онд 47.8 хувьд, 2021 онд 41 хувьд хүргэхээр төлөвлөсөн байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

СЗХ: Санхүүгийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэл тогтвортой байна

Банкнаас бусад санхүүгийн салбарын талаарх иргэдийн итгэл, хүлээлтийн судалгааг Санхүүгийн зохицуулах хороо танилцууллаа. "NRCC" компанийн хийсэн судалгаагаар 2018 оны I улиралд санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад харьцангуй тогтвортой байна гэж дүгнэсэн байна. Тухайлбал, энэ хугацаанд иргэдийн Банк бус санхүүгийн байгууллагад итгэх итгэл 20 хувиар өсөж, "мэдэхгүй" гэсэн хариулт 40 хувиар буурсан байна.

Эрэгтэйчүүдийн хөрөнгийн биржид итгэх итгэл эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа бөгөөд 35 ба түүнээс доош настай хүмүүсийн хөрөнгийн биржид итгэх итгэл 35-аас дээш настай иргэдтэй харьцуулахад 60 хувь илүү байна.

Иргэдийн 18.8 хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан гэж хариулсан бол 51.0 хувь нь үгүй, 30.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. Үүнийг жилийн өмнөх судалгаанд оролцогсдын 14.0 хувь нь арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсантай харьцуулбал иргэдийн хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол 4.8 пунктээр өссөн байна. Бүрэн дундаас дээш боловсролтой иргэдийн арилжаанд оролцох сонирхол доогуур боловсролтой иргэдээс 40 хувиар өндөр байна. Эрэгтэйчүүдийн арилжаанд оролцох сонирхол эмэгтэйчүүдээс 1.7 дахин өндөр байна.

Эх сурвалж: BloombergTv.mn, FRC.mn

Хэрэглэгчийн итгэлийн индекс таван улирал дараалан өсөв

Монгол Улсын хэрэглэгчийн итгэлийн индекс 2018 оны I улирлын байдлаар өмнөх оноос 3.9 пунктээр өсөж, 82 болсон талаар "Эн Ар Си Си" компани мэдээллээ. Ингэснээр хэрэглэгчийн итгэлийн индекс таван улирал дараалан өсөлттэй гараад байгаа юм. Хэрэглэгчийн итгэлийн индекс өсөхөд "Өнөөгийн байдлын индекс" 6.5 пунктээр, "Ирээдүйн хүлээлтийн индекс" 2.2 пунктээр өссөн нь голлон нөлөөлсөн байна. "Өнөөгийн байдлын индекс" өсөхөд ойрын ирээдүйд бизнесийн нөхцөл сайжирна гэсэн хүлээлт голчлон нөлөөлсөн гэж судалгааны баг онцоллоо. Хэрэглэгчийн итгэлийн индексээс онцолбол "Өрхийн санхүүгийн байдал сайжирсан" гэж хариулсан өрхийн тоо жилийн өмнөхөөс 4.2 пунктээр, "Муудсан" гэж хариулсан өрхийн тоо 2.6 пунктээр өсжээ.

Харин зээл авахаар төлөвлөж буй иргэдийн тоо жилийн өмнөхөөс зургаан пунктээр өссөн байна. Макро эдийн засгийн гол үзүүлэлтийн хувьд нийслэлийн иргэд "инфляц жилийн эцэст 4.2 хувьтай гарна" гэсэн хүлээлттэй байна. Харин ам.долларын ханшийг ирэх зургаан сарын хугацаанд өснө гэж үзжээ.

Хэрэглэгчийн итгэлийн индексийн тайланг "Эн Ар Си Си" ХХК болон Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв хамтран 2009 оноос хойш гаргаж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.